

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ СОЁЛ, УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР
ТУСГАГДСАН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ**
/Жилийн эцэс/

2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

2.6. Үндэсний агуулга бүхий соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, хотын соёлыг дээдэлсэн иргэнийг төлөвшүүлнэ.

2.6.1. Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж, олон улсын стандарт шаардлагад нийцсэн соёл, урлагийн байгууллагын шинэ барилга байгууламжуудын гадна тохижилт, газрын асуудлыг шийдвэрлэнэ.

2.6.1.1. Үндэсний номын сангийн хуучин барилга, Дуурь бүжгийн Эрдмийн театр, Драмын Эрдмийн театрын барилгуудыг сэргээн засварлана.



Үндэсний номын сангийн барилгыг сэргээн засварлах зураг төсвийн зардал 400,0 сая төгрөгийг нийслэлийн 2021 оны төсөвт “Шинээр баригдах барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, мастер төлөвлөгөө, зөвлөх үйлчилгээнд зориулсан зардал”-д тусган хэрэгжүүлэхээр Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй. Үндэсний номын сан, Дуурь бүжгийн эрдмийн театр, Драмын эрдмийн театрын барилгуудыг соёлын өвийн бүртгэлд бүртгэн дүүргийн хамгаалалтын зэрэглэлд авах дурсгалуудын жагсаалтад оруулан НИТХ-аар шийдвэрлүүлэхэд бэлэн болсон.

2.6.1.2. Үндэсний урлагийн их театр, Үндэсний номын сан, Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театр, Хүүхдийн соёлын өв, хөгжлийн төв, Хүүхэд залуучуудын театрын барилгыг шинээр барих газрын асуудлыг шийдвэрлэнэ.


ҮНДЭСНИЙ УРЛАГИЙН ИХ ТЕАТР

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 29/33 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 4.2.14 дэх заалтын дагуу улсын төсвийн хөрөнгөөр Сүхбаатар дүүргийн 9,11 дүгээр хороо, 10 га газарт Үндэсний урлагийн их театр баригдахаар тусгагдсан бөгөөд тус байршлын нөлөөлөлд 160 нэгж талбар өртсөн. Улмаар Нийслэлийн Засаг даргын “Газар эзэмших эрх олгох тухай” 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/635 дугаар захирамжаар 5,5 га газарт Үндэсний урлагийн их театрт эзэмшүүлсэн.



ХҮҮХДИЙН НОМЫН САН, ХҮҮХЭЛДЭЙН ТЕАТР

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театр барих газрын батламжийг 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Монголын үндэсний олон нийтийн телевизээр зохион байгуулсан хандивын аяны үеэр Соёлын сайдад гардуулан өгсөн. Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/23 дугаар захирамжаар Чингэлтэй дүүргийн 5-р хорооны нутаг дэвсгэрт 1,09 га газрыг шийдвэрлэсэн.



ҮНДЭСНИЙ НОМЫН САН

Нийслэлийн Засаг даргын захирамжаар СБД-ийн 7-р хорооны нутаг дэвсгэрт 0.3 га газар олгосон. Барилгын ажил явагдаж байна.

ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ТЕАТР

Сонгинохайрхан дүүргийн 5-р хороонд баригдаж байсан Соёлын ордны барилгыг Ерөнхий сайдын шийдвэрээр Хүүхэд залуучуудын театрын зориулалтаар ашиглахаар болсон.

2.6.2. Улаанбаатар хотын музей болон Улаанбаатар хотын Нийтийн төв номын сангийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

2.6.2.1. Улаанбаатар хотын нийтийн төв номын сан болон салбар 4 номын сан, алслагдсан 3 дүүргийн Соёлын ордны номын санд фондын баяжилтыг жил бүр хийнэ.

УБХНТС-ийн салбарууд, алслагдсан дүүргүүдийн номын сангуудад 2021 онд фондын баяжилт хийх зардал улс, нийслэлийн төсөвт тусгагдаагүй. Тайлант хугацаанд 1107 нэр төрлийн 3742 ширхэг номыг (Тендер, бэлэг, орлуулах) гэх мэт нийтдээ 83,213,632 төгрөгийн номын баяжилтыг хийж бүрдүүлэн авч каталогжуулан уншигчдад хүргэсэн.

1107 нэр төрлийн 3742 шихэг номын мэдээллийг электрон каталогт оруулан 3742 ширхэг RFID-ийн бар кодон tag-ийг идэвхжүүлэн наасан ба 558 номын мэдээллийг Коха программын электрон каталогт засвар хийж, ном зүйн стандартыг ханган ажилласан.

Ковид-19 цар тахлын тархалтын улмаас хөл хорио тогтоон үйл ажиллагаа явуулаагүй ба мэргэжлийн байгууллагын шийдвэрүүдээр халдварт хамгааллын дэглэмийг баримтлан 50 хувийн дүүргэлттэйгээр 5 сарын хугацаанд уншигч, хэрэглэгчдэд 43112 ном, хэвлэл танхимаар, 2093 номыг гэрээр олгож үйлчилсэн.

2.6.2.2. Улаанбаатар хотын нийтийн төв номын сан болон салбар 4 номын сан, алслагдсан 3 дүүргийн Соёлын ордны номын санд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, алслагдсан дүүргүүдийн Соёлын ордны номын санд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх орчныг сайжруулах хөрөнгө оруулалтын зардал 2021 оны Нийслэлийн төсөвт тусгагдаагүй.

Иймд Улаанбаатар хотын нийтийн төв номын санд Бүгд Найрамдах Солонгос Улсын Соёл, Боловсролын яамны дэмжлэгтэйгээр хэрэгжих төслийн хүрээнд шийдвэрлэхээр төлөвлөж байна. Нийслэлийн алслагдсан дүүргүүд болох Багануур, Багахангай, Налайх дүүргүүдэд шинээр Соёлын ордон барих ажил хэрэгжиж байгаа бөгөөд тус Соёлын орднуудын барилгын ажлыг гүйцэтгэгч компаниудад хандан барилгын зураг төсөвт “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх орчин нөхцөл”-ийг стандартын дагуу хийх талаар зөвлөмж санал хүргүүлсэн. Үүний дагуу барилгын зурагт хөгжлийн бэрхшээлтэй хүний орц, гарц, налуу шатны зураг тусгагдсан бөгөөд барилгын суурийн ажлууд хийгдэж байна.

2.6.2.3. Улаанбаатар хотын музейн барилгыг засварлаж үйл ажиллагааг боловсрол, түүх соёлын танин мэдэхүйн чиглэлээр өргөжүүлэн хөгжүүлнэ.



Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/619 дүгээр захирамжаар “Улаанбаатар хотын музейн барилгыг түүхэн дурсгалт байгууламж хэлбэрээр сэргээн засварлах, өргөтгөх барилгын зураг төсөл”-ийг боловсруулахаар шийдвэрлэсэн.

2020-2021 онд “Тито архитектс” ХХК загвар зураг, иж бүрэн ажлын зургийг гүйцэтгэж дууссан ба зураг төслийг мэргэжлийн байгууллагуудаар хянуулж, батлуулсан. Зураг төсвийн дагуу гарсан 6,8 тэр бум төгрөгийн барилгын ажилд шаардагдах зардлыг 2022 оны Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлхээр 2022 оны хөгжлийн төлөвлөлтөд тусган НЗДТГ-т хүргүүлсэн.





2.6.3. Хотын соёлыг төлөвшүүлж түгээн дэлгэрүүлэх ажлыг бүх шатанд зохион байгуулна.

2.6.3.1. "Хотын соёл" цуверал контент бий болгож цахим аян хэрэгжүүлнэ.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, нийслэлийн иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, хотын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн “Хотын соёл” аяныг Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/302 дугаар захирамжийн дагуу удирдамж боловсруулан гаргаж нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан.

Үүнд:

1. “ХОТ” бичил цуврал нэвтрүүлэг 10 дугаар
2. “Бидний тухай бид” цуврал нэвтрүүлэг 12 дугаар
3. Нөлөөлийн 3D цуврал анимэйшэн 50 дугаар
4. Оюутан залуусын дунд контентийн уралдаан зэргийг зохион байгуулсан.



Сурталчилгааны хэвлэмэл материал

5. А3 плакат 5000 ширхэг
6. Фото стикер 40,000 ширхэг
7. Автобусны наалт 70 ширхэг
8. 12 байршилын самбарт сурталчилгааны хулдаасан хэвлэл бэлтгэн 14 хоногийн хугацаатай байршуулсан.



“Хотын соёл” аян хүрээнд нөлөөлийн 90 контент, 120 зурагт постыг оруулж, давхардсан тоогоор 3,600,000 гаруй хүнд хүргэсэн.

Нийслэлийн нутгийн захиргааны 30 байгууллагын цахим хуудсыг НСУГ-ын “Соёлтой БолГоё” цахим хуудастай холбон тус аяны хүрээнд хийгдсэн соён гэгээрүүлэх нөлөөллийн видео контентийг нийслэлийн иргэдэд хүргэж ажилласан.

НЗДТГ-ын даргын 2021 оны А/160 дугаар тушаалаар “Хотын соёл” аяныг дүгнэх ажлын хэсэг байгуулагдан, тус аяныг хэрэгжүүлэхэд идэвх санаачилга гарган ажилласан хэрэгжүүлэгч агентлаг, харьяа байгууллага, дүүргийг шалгаруулах ажлыг зохион байгуулж байна.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд өөрсдийн байгууллагын онцлогт тохируулан төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний дагуу давхардсан тоогоор 190 гаруй төрлийн ажлыг зохион байгуулсан.



“Хотын соёл” аяны хүрээнд зохион байгуулагдсан ажил болон түүнд хамрагдсан хүний давхардсан тоо



2.6.4. Урлагийн олон төрөл зүйлийг жигд хөгжүүлж, иргэд, олон нийт болон гадаадын жуулчдад сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлж, үндэсний агуулга шингэсэн бүтээлийн тоог нэмэгдүүлнэ.

2.6.4.1. Үндэсний агуулга шингэсэн уран бүтээлийг дэмжинэ.

Үндэсний үнэт зүйл, өв соёлыг хойч үедээ өвлөн уламжлуулах, сурталчлан таниулах зорилгоор "Монголын их бэлгэшээл" баярын тусгай дугаарыг Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизтэй хамтран хийж, MNB 1,2 дугаар суваг, Mongolian National Broadcaster цахим хуудсаар дамжуулж, олон нийтэд хүргэсэн.





2.6.4.2. "Улаанбаатар" олон улсын кино наадам, Сонгодог урлагийн гала фестивалийг жил бүр зохион байгуулна.

Монголын урлагийн зөвлөлтэй хамтран ажиллах гэрээ байгуулан "Улаанбаатар" Олон Улсын кино наадмыг 13 дахь удаагаа 10-р сарын 18-наас 24-ний өдрүүдэд Тэнгис кино театрт зохион байгуулсан. Наадмын хүрээнд Монгол, Орос, Франц, Герман, Иран, Малайз, Мьянмар, Швейцар, Энэтхэг, Япон зэрэг улсын 18 бүрэн хэмжээний уран сайхны киног 2700 үзэгчдэд хүргэсэн. Мөн "Монгол ба Зүүн Өмнөд Азийн Бүсийн Кино Форум" сургалтыг цахим болон танхимаар 100 гаруй уран бүтээлчдэд зохион байгуулсан.



Сонгодог урлагийн гала фестивалийг телевизийн нэвтрүүлэг хэлбэрээр зохион байгуулж Үндэсний эрх чөлөөний өдрөөр МҮОНТ-ээр дамжуулж 100,000 үзэгчдэд хүргэсэн. Тус нэвтрүүлэгт үндэсний сонгодог урлагийн талаар үзэгчдэд мэдлэг олгох зорилгоор бүтээсэн бөгөөд "Шивээ хиагт", "Учиртай гурван толгой", "Ламбугайн нулимс", "Хан бүргэд", "Чингис хаан", "Хөхөө намжил", "Уран хас" зэрэг 7 дуурийн хэсгээс оруулж өгсөн онцлогтой.



Сонгодог урлагийн “Гала фестиваль”-д зарцуулсан хөрөнгө	
■ 2020 он	90,040,000
■ 2021 он	60,000,000

Сонгодог урлагийн “Гала фестиваль”-ийн үзэгчдийн тоо	
■ 2020 он	30,000
■ 2021 он	100,000

2.6.4.3. Иргэд, жуулчдад зориулсан нийтийг хамарсан урлагийн тоглолт, үйл ажиллагаа зохион байгуулна.

Иргэд жуулчдад зориулан зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд “Жазз сити риваивал” жазз хөгжмийн наадам, “Contemporary series #01-05” цуврал үзэсгэлэн, “UB COVER-2021” цахим дууны наадам, “Урлагийн хот Улаанбаатар” аян, “Юу Би Комеди” арга хэмжээ, соёлын биет бус өвийн танилцуулга, угийн бичгийн цуврал контент, дэлхийн сонгодог өгүүллэгийн товчлолын видео зэрэг 8 үйл ажиллагааг тус тус зохион байгуулж, нийт 193,0 мянга гаруй иргэдэд хүргэсэн.



2.6.5. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг оюуны өмч зохиогчийн эрх, инновацид тулгуурлан хөгжүүлнэ.

2.6.5.1. Улаанбаатар хотын Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих инкубатор төв байгуулна.

Улаанбаатар хотын Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих инкубатор төв байгуулах талаар холбогдох байгууллагуудтай зөвшилцэн Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны 2022 оны төлөвлөгөөнд тусгуулахаар хүргүүлсэн. Мөн Дамбадаржаа дэд төвийн төлөвлөлтийн хурээнд Дамбадаржаалин хийдийг сэргээн засварлаж аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон түүх соёлын үйл хөдлөх дурсгалд сууринласан соёлын орон зайд бий болгож Цогчин дуганыг соёлын бүтээлч үйлдвэрлэлийн инкубатор төв болгон ашиглах боломжийг судалж байна.

Монгол Улсын Соёлын яам арваннэгдүгээр сарын 1-нээс эхлэн “Соёлын бүтээлч сар” аяныг зарласан. Уг аяны хурээнд “Бүтээлч хот Улаанбаатар” зөвлөлдөх уулзалтыг 2021 оны 11-р сарын 04-ний өдөр зохион байгууллаа.

“Бүтээлч хот Улаанбаатар” зөвлөлдөх уулзалт нь соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлыг нийслэл хотын хөгжлийн дунд хугацааны хөтөлбөрт уялдуулан тусгах, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэх, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх зорилготой. Уулзалтад Нийслэлийн Соёл урлагийн газрын дарга Ж.Дамдинцэрэн “Улаанбаатар хотын соёлын бүтээлч үйлдвэрлэлийн өнөөгийн байдал” сэдвээр илтгэл тавьж оролцсон.



2.6.6. Нийслэлийн харьяа соёл, урлагийн байгууллагуудын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгож, иргэдэд үйлчлэх соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

“Улаанбаатар чуулгын үйл ажиллагааг өргөжүүлж, театрын статустай болгох асуудлыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж “Улаанбаатар театр” нэртэй болж, 11 дүгээр сарын 08-ны өдрийн 148 дугаар тогтоолоор Улаанбаатар театр орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчилж, дурмийг хавсралтаар баталсан.



2.6.7. Улс, нийслэл, дүүргийн хамгаалалтад байх түүх соёлын дурсгалт газар, барилга байгууламжийг бүсчлэн хувааж аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгоно.

2.6.7.1 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг танилцуулах, сурталчлах аппликацыйн бүтээж, соёлын аялал жуулчлалын эргэлтэд оруулах ажлыг үе шаттай зохион байгуулна.

Нийслэлийн нутаг дэвсгэрт байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудыг QR кодоор танилцуулах аппликацыйн бүтээж хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Дэмжлэг үзүүлэх тухай” А/581 дүгээр захирамж, Нийслэлийн Соёл, урлагийн газрын даргын 2021 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн “Дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах тухай” А/26 дугаар тушаалын дагуу “Чингис системс” ХХК-тай хамтран ажиллах гэрээг 2021 оны 08 дугаар сарын 02ны өдөр байгуулан ажилласан.

Уг гэрээний дагуу “Чингис системс” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Mongol events” төслийн хүрээнд бүтээгдэж буй аппликацыйнд “Нийслэл хотын түүх, соёлын дурсгалууд” гэсэн цэс оруулж, Монгол




Улсын Засгийн газрын 2020 оны “Жагсаалт батлах тухай” 13 дугаар тогтоолоор батлагдсан Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал, БСШУС-ын сайдын 2020 оны “Жагсаалт батлах тухай” А/161 дүгээр тушаалаар батлагдсан Нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал, НИТХ-ын 2008 оны 75 дугаар тогтоолоор батлагдсан дүүргийн хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгал 144, нийт 173 дурсгалын мэдээллийг бэлтгэн оруулсан. Тус аппликацыйнд жил бүр мэдээллийн баяжуулалт хийгдэх юм.


Улс, нийслэл, дүүргийн хамгаалалтад байх түүх соёлын дурсгалт газар, барилга байгууламжийг бүсчлэн хувааж аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох зорилтын хүрээнд ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй хамтарсан төсөл хэрэгжүүлэн ажиллалаа.

Сүхбаатар дүүргийн 20 дугаар хороонд орших “Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булшны судалгаа”-ны төслийг 2021 оны 07 дугаар сарын 10-наас 08 дугаар сарын 10-ны хооронд, Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт орших “Туулын Хар Түнэ ордны археологийн судалгаа” төслийг 2021 оны 06 дугаар сарын 25-наас 08 дугаар сарын 18-ны хооронд тус тус хэрэгжүүлсэн.





ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА



Ж.ДАМДИНЦЭРЭН

Ч.ДАРИЙМАА

ХЯНАСАН:
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ОЮУНЗУЛ

БОЛОВСРУУЛСАН:
ХАМТЫН АЖИЛЛАГАА, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

J.Дамдинцэрэн